



CPL1 R0
Хянан засварласан

Мөрдөж эхлэх огноо: 9/7/2018

БИДНИЙ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

CM ORN DIR CPL1 R0 « Code Ethique d'Orano » -ын орчуулга

Дэлхийн олон оронд салбартай **Orano** групп нь нарийн түвэгтэй орчинд үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ утгаараа, бид өмнөө тавьсан зорилтуудаа биелүүлэх, бизнесийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахын тулд бүхий л үйл ажиллагаагаа дараах нийтлэг үнэт зүйлс дээр тулгуурлан явуулдаг. Үүнд:

**Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж
Байнга сайжруулах
Хувь хүнийг хүндэтгэх, хөгжүүлэх
Уялдаа холбоо ба багийн тоглолт
Үлгэр жишээч, нэгдмэл, хариуцлагатай байх**

Эдгээр үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийн тулд баримтлавал зохих зарчим, биеэ авч явах ёс, дүрмүүдийг энэхүү Ёс зүйн дүрэмд тодорхойлсон. Энэхүү Дүрэм нь манай байгууллагын соёлын тусгал бөгөөд, ялангуяа, тогтвортой хөгжлийг дэмжиж, хүний эрхийг хүндлэн дээдлэх тал дээр оролцогч талуудын өмнө бидний хүлээсэн үүргийг илэрхийлдэг. Дүрэм нь манай нийт ажилтан, удирдлагуудын хувьд лавлах нь байх бөгөөд компанийн бизнесийн үйл ажиллагааг амжилтанд хүргэхэд хамтран ажиллахыг зорьж буй хүн бүрээс бидний хүлээх үр дүн, түүнд тавих шаардлагыг тодорхойлдог.

Интранет болон Интернетээс хүн бүрийн үзэх боломжтой энэхүү Ёс зүйн дүрмээрээ Групп маань авилга, хууран мэхлэх аливаа үйл ажиллагаанаас чанарт үзүүлэх эрсдлийг эрс эсэргүүцэж, тэдгээрийн эсрэг бодлого баримталдагаа дахин батлаж байна.

Хариуцлагатай компанийн хувьд, үйл ажиллагаа маань доор дурдсан, нэн тэргүүний хоёр зарчимд тулгуурладаг. Үүнд:

- **Үйл ажиллагаандаа цөмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах асуудлаар бидний тавьсан зорилттой нийцэж буй хамгийн өндөр шаардлагуудыг хангах, тэдгээрийг мөрдөж ажиллах;**
- **Шударга ёсыг эрхэмлэж, авилга, хууран мэхлэх аливаа үйл ажиллагаа, шударга бус өрсөлдөөнтэй тууштай тэмцэж, эдгээртэй холбоотой хамгийн хатуу хэм хэмжээг дагаж мөрдөх.**

Эдгээр үнэт зүйлсийг уламжлуулан түгээх, бидний зарчмуудыг баримтлан ажиллах нь Группын бүх нэгж, салбарын менежерүүд болон ажилтнууд, түүнчлэн манай үйлдвэрлэл, худалдааны түншүүдийн үүрэг нь юм.

Энэхүү Ёс зүйн дүрмийг ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хэрхэн хэрэгжүүлэх тухай та бүхний асуултанд Группын Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан хэлтсийн ажилтнууд хариулна.

Гүйцэтгэх хороо, Төлөөлөн удирдах зөвлөл болон бид бүгд та бүхнийг тус бүрдээ энэхүү Ёс зүйн дүрмийг чандлан биелүүлнэ хэмээн найдаж байгаа бөгөөд ингэснээр бид үнэлэмжийг нэмэгдүүлэх замаар үйлчлүүлэгч болон түншүүдийнхээ тогтвортой бөгөөд үр ашигтай өсөлтийн суурийг хамтдаа бэхжүүлж чадна.

Филип Кнорэ
Ерөнхий захирал

Филип Варэн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
дарга

1. ӨМНӨХ ҮГ

Орано групп ёс зүйн хувьд болон хууль тогтоомжийг мөрдөж ажиллахдаа үлгэр жишээч байхыг эрхэмлэдэг.

Энэхүү Дүрэм нь бидний үнэт зүйлсийг танилцуулахын зэрэгцээ Групп үйл ажиллагаагаа явуулдаг дэлхийн бүх улс орон дахь нийт ажиллагсдын хувьд заавал дагаж мөрдвөл зохих ёс зүйн хэм хэмжээг тодорхойлно. Орано групп өөрийн үйлдвэрлэлийн болон худалдааны түншүүд, ялангуяа ханган нийлүүлэгч болон гэрээт компаниудаараа мөн эдгээр үнэт зүйлс, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэхийн төлөө ажилладаг.

Мөн түүнчлэн Орано группын бүх ажиллагсдын хувьд дагаж мөрдвөл зохих үнэт зүйлсийг бизнес төлөвлөгөөнийхөө хүрээнд тодорхойлсон. Тэдгээр үнэт зүйлсийн дотроос шударга байдал, цөмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах зарчмыг аливаа үйл ажиллагаандаа, шийдвэр гаргах бүртээ удирдлага болгодог.

Орано групп үйл ажиллагаагаа явуулахдаа Нэгдсэн үндэстний байгууллагаас баталсан *Хүний эрхийн түгээмэл тунхаглалд* тодорхойлсон Хүний эрхийг хүндэтгэдэг. Бид үйл ажиллагаа явуулж буй улс орнуудынхаа хууль тогтоомж болон Группийн дотоод дүрэм, журмыг чанд мөрддөг. Групп бүх ажиллагсдынхаа эрхийг хүндэтгэдэг бөгөөд аливаа тохиолдолд салбарынхаа хамгийн өндөр түвшний стандартыг хангаж ажиллахыг зорьдог.

Орано группийн түншлэлд хандах хандлагыг шударга ёс, ил тод болон нээлттэй байдал тодорхойлдог. Манай Групп байгаль орчин, эдийн засаг, нийгмийн болон нийтийн хариуцлагын хувьд компанийн гүйцэтгэлийг бодитоор үнэлэхэд шаардлагатай үнэн зөв мэдээллээр хангахыг эрмэлздэг.

2. БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

Цөмийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал нь Орано группийн үндсэн зарчмыг тодорхойлох бөгөөд эдгээр нь ажилтан бүрийн хувьд нэн тэргүүний зорилт байна.

Түүнчлэн, бид доор дурдсан нийтлэг үнэт зүйлсүүдийг эрхэмлэдэг. Үүнд:

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж: сонсох, прагматик байх, урьдчилан төлөвлөх, хариу үйлдэл үзүүлэх, санаачилгатай байх;
- Байнга сайжруулах: ажлын хуваарилалт, алдаа гаргах эрх, санаачилгатай байх, бүтээлч байдал, үр дүнд анхаарах, гадагш чиглэсэн байх, сорилтыг даван туулах;
- Хувь хүнийг хүндэтгэх, хөгжүүлэх: сонсох, шаардлага тавих, халуун дотно харилцаа, ялгаатай байдлыг хүндэтгэх, хувь хүний хувьд болон ажил мэргэжлийн хувьд хөгжих боломж;
- Уялдаа холбоо ба багийн тоглолт: хамтын ажиллагаа, ил тод байдал, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах;
- Үлгэр жишээч, шударга, хариуцлагатай байх: менежерийн зориг, ажлын талбар дээр ажиллах, стандартыг мөрдөх, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих, хууль тогтоомжийн хүрээнд ажиллах, компанийн дотоод дүрэм, журмыг дагаж мөрдөх, ажиллагсдын эрхийг хүндэтгэх.



orano

3. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ӨМНӨ ОРАНО ГРУППИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

3.1 ГРУПП НУТАГ ДЭВСГЭРТ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ УЛС ОРНУУДЫН ХУВЬД

Орано групп нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаагаа явуулж буй улс орнуудын хүчин төгөлдөр хууль тогтоомж, дүрэм журам, мөн түүнчлэн аюулгүй байдлыг хангах эрх бүхий байгууллагуудын удирдамж, зааварчилгааг чандлан мөрддөг.

3.2 ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ХУВЬД

Үйлчлүүлэгчдийнхээ хүлээлтийг урьдчилан харж, хангахын тулд Групп тэднийг байнга сонсохыг эрхэмлэнэ. Бид үйлчлүүлэгчдээ чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах замаар тэдний өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхийг эрмэлздэг.

Орано үйлчлүүлэгчдийнхээ соёлыг хүндэтгэж, тэдний нэр төр, ашиг сонирхлыг хамгаалдаг. Орано өөрийн үйлчлүүлэгчид болон түншүүдээс хууль тогтоомж, холбогдох журмын хүрээнд танилцах эрх олгосон өгөгдөл мэдээлэл, нөү-хаугийн нууцыг өөрсдийнх мэт чанд хамгаалдаг.

3.3 АЖИЛЛАГСДЫН ХУВЬД

Ажиллагсдын тоонд Орано группийн бүх салбар, нэгжийн удирдлага, менежер, ажилтан, дадлагажигч болон дагалдан ажиллагч бүгд багтана. Ялангуяа, компанийн удирдах албан тушаалтнууд болон менежерүүд үлгэр жишээ үзүүлэх ёстой.

Орано групп хүний нөөцөө нас, гарал үүсэл, хүйс, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, иргэншил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, гадаад төрх эсвэл хөгжлийн бэрхшээлээр ялгаварлахгүйгээр бүрдүүлдэг.

Орано групп ажиллагсдынхаа хувийн эрх чөлөөг хүндэтгэж, улс төр, философийн болон шашны итгэл үнэмшлийн тухайд төвийг сахисан байр сууринаас ханддаг хэдий ч ажлын байран дахь аливаа ухуулга сурталчилгааг хориглодог.

Орано групп удирдлага болон ажиллагсдын хооронд яриа хэлэлцээ хийхийг эрхэмлэдэг бөгөөд үүнийг шударга, шулуун байдлаар явуулдаг.

Орано ажиллагсдынхаа мэдлэг, ур чадварыг ажлын байрныхаа шаардлагыг хангахуйц түвшинд байлгах зорилгоор сургалтын хөтөлбөрүүдийг санал болгодог бөгөөд энэ нь тэдэнд мэргэжил дээшлүүлэх боломж олгодог.

3.4 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙНХЭЭ ХУВЬД

Орано групп компанийн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэхдээ хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгө оруулалт болон боломжит өгөөжийг нэмэгдүүлэхийг зорихын зэрэгцээ бүх хувьцаа эзэмшигчидтэйгээ тэгш харилцаж, тэднийг санхүүгийн үнэн зөв, шаардлагатай мэдээллээр хангахад онцгой анхаардаг.

3.5 ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД БОЛОН ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХУВЬД

Орано групп үйлчлүүлэгчиддээ стандартын өндөр түвшинд үйлчилгээ үзүүлэх үүднээс ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчидтэйгээ шударга өрсөлдөөний хүрээнд, түншлэлийн тогтвортой харилцааг тогтоон ажиллахыг эрмэлздэг.

Тийм учраас зөвлөгөө авч, судалгаа хийх үе шатаас эхлэн нийт ханган нийлүүлэгчид, гэрээлэгчид, түншүүдтэйгээ харилцан хүндэтгэлтэй, найдвартай, үнэнч, шударга, бодит харилцаатай ажиллах үүрэг хүлээдэг.

Орано групп ханган нийлүүлэгчдийнхээ нэр төр, мэдээллийнх нь нууцыг өөрийн мэт хамгаалдаг.



3.6 ОЛОН НИЙТИЙН ХУВЬД

Орано групп нийтийн өмч болох байгаль орчныг хамгаалах нь байгаль дэлхийтэй харилцах харилцаанд хүний бүхий л ая тух, сайн сайхан байдлыг хангана гэж үздэг. Группийн байгаль орчны бодлого, эрсдлийг хянах хөтөлбөрүүд энэ зарчимд тулгуурладаг ба бидний үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөг багасгаж, нутаг дэвсгэрт нь Групп үйлдвэрлэлийн болон уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг бүс нутагт биологийн олон төрөл зүйлийг хамгаалах зорилго тавьдаг. Түүхий эдийг (ялангуяа усыг) дахин боловсруулах замаар байгалийн нөөцийг хамгаалж байгаа нь Орано группийн эх дэлхийдээ хандах зөв хандлагыг илтгэнэ.

Орано групп олон нийтийн хэлэлцүүлгийг дэмжих, түүнд оролцоход бэлэн байдгаа илэрхийлдэг. Бид стратегийн болон технологийн сонголтоо шударгаар тайлбарлах, шийдвэр гаргагчид болон ард иргэдэд үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өгөхөд анхаарч ажилладаг. Энэ утгаараа бид мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг ашиглахдаа ёс зүйтэй ханддаг.

3.7 ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ БОЛОН БУСАД ЗОРИЛТУУД

Орано групп нь ЭЗХАЗБ-ын Үндэстэн дамжсан корпорациудад зориулсан Удирдамжийн зарчим болон Нэгдсэн үндэстний байгууллагын Даян дэлхийн гэрээний зарчмыг хэрэгжүүлж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмждэг. Энэхүү зорилтуудын хүрээнд Орано групп нь хүний эрхийн талаарх олон улсын хууль тогтоомжийг хүндэтгэн сурталчилж, хүний наймаа, албадан болон хүчээр хөдөлмөр эрхлүүлэх эсвэл хүүхдийн хөдөлмөрийн аливаа хэлбэрийг ашигладаггүй бөгөөд ханган нийлүүлэгч, гэрээлэгчиддээ мөн тус шаардлагыг тавьдаг.

4. ОРАНО ГРУППИЙН ХҮЛЭЭЛТ

4.1 АЖИЛЛАГСДЫН ХУВЬД

Орано группын нийт ажиллагсад ажил үүргээ гүйцэтгэхдээ НҮБ-аас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тодорхойлсон хүний эрхийг хүндэтгэдэг.

Группийн ажиллагсад нь үнэнч шударга байж, ажиллаж буй улс орныхоо хүчин төгөлдөр хууль тогтоомж, дүрэм журам болон Орано группийн Ёс зүйн дүрэм, бусад бодлого, журмууд, мөн түүнчлэн чанарын шаарлагатай холбоотой журмуудыг мөрдлөг болгон ажилладаг бөгөөд Группийн хөрөнгийг өөрсдийн мэт гамтай зарцуулна. Түр ажиллагсад мөн дээрхтэй ижил үүрэг хүлээнэ.

Орано группийн ажиллагсад үйлчлүүлэгчдээ гэсэн сэтгэлд хөтлөгдөнө. Тэд ажилдаа мэргэжлийн үүднээс, өндөр ур чадвартай, нягт нямбай байдлаар ханддаг. Тэдний өөрсдийн үзүүлж буй болон аутсорсингийн үйл ажиллагаа нь бүрэн эргэх холбоотой байдаг.

Группийн ажиллагсад Орано-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг төгс үзүүлэхэд анхаарах бөгөөд Группийн үйл ажиллагаанд тустай мэдлэгийг шилжүүлэн нэвтрүүлж, өмнөх туршлагаа тогтмол ашиглана.

4.2 ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИД БА ГЭРЭЭЛЭГЧДИЙН ХУВЬД

Орано групп нь өөрийн ханган нийлүүлэгчид, гэрээлэгчид, санхүүгийн түншүүд, зөвлөхүүд болон арилжааны хөндлөнгийн зуучлагч нараар (дистрибьютерүүд, агентууд г.м.) мөн энэхүү Ёс зүйн дүрмээ мөрдүүлэхийг эрмэлздэг. Мөн тэдний ханган нийлүүлэгчид эсвэл гэрээлэгчид, тус Группийн үйлдвэрлэлийн болон худалдааны түншүүд энэхүү дүрмийг баримтлах ёстой.

Орано групп бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийн гинжин хэлхээний бүхий л үе шатанд ханган нийлүүлэгчид, гэрээлэгчид нь энэхүү Ёс зүйн дүрмийг чанд даган мөрдөж буй эсэхэд хяналт тавих, шалгах эрхтэй.

5. ОРАНО ГРУППИЙН ХЭМЖЭЭНД ХҮЧИН ТӨГӨЛДӨР ҮЙЛЧИЛДЭГ ДҮРЭМ, ЖУРМУУД

Дараах үйл ажиллагааны дүрэм, журмуудыг Группийн нийт ажиллагсад, ханган нийлүүлэгчид болон гэрээлэгчид заавал биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд холбогдох бодлого, журмаар нарийвчлан тодруулах боломжтой.

5.1 АМЬ НАС, ӨМЧ ХӨРӨНГИЙГ ХАМГААЛАХ

Ажиллагсад нь амь нас, өмч хөрөнгөтэй холбоотой аливаа зөрчлийг олж мэдвэл өөрийн шууд удирдлагад нэн даруй мэдэгдэнэ.

5.1.1 Хүмүүс, эрүүл мэнд, чанар, байгаль орчин

Орано групп үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрхэм чанарыг чандлан хүндэтгэх ба түүний дотор аливаа дарамт шахалт, хүний эрх болон хүүхдийн эрхийг зөрчихийг хориглоно.

Орано өөрийн бүх сайтууд, ажлын талбар дээрх бүхий л үйл ажиллагааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам болон Группийн эрүүл мэнд, чанар, аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах бодлогод нийцүүлж, тэдгээрийг мөрдөх нөхцөлийг ханган ажиллана.

Эдгээр үүргийг зөрчсөн тохиолдолд тодорхой түвшинд, шаардлагатай бол Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан хэлтэст мэдэгдэх шаардлагатай бөгөөд үүний үндсэн дээр гарсан алдаа зөрчлийн бодит байдлыг нэн даруй шалгах арга хэмжээг авч, шаардлагатай аудитыг хийж, нотлогдсон тохиолдолд тэрхүү зохисгүй үйл ажиллагааг даруй зогсоох арга хэмжээ авна.

5.1.2 Нэр хүнд, брендийн нүүр царай

Орано группийн нэр хүнд бол тус байгууллагын үнэт өвийн салшгүй хэсэг юм.

Группийн ажиллагсад Орано группийн нэр хүнд, нүүр царай эсвэл найдвартай байдлыг сэвтээх аливаа зүйл хийх, хэлэхгүй байх үүргийг өдөр тутамдаа хүлээнэ. Үндэсний хэмжээнд болон олон улсын харилцаанд, бусдын нэр төрийг гутаасан, доромжилсон үйлдэл гаргах, бусадтай санаатайгаар бүдүүлгээр эсвэл ёс зүйгүй харьцахыг хориглоно.

5.1.3 Биет бус соёлын өв

Ажиллагсад “Нууц” эсвэл “Хязгаарлалтай” хэмээн тэмдэглэсэн эсэхээс үл хамааран Группийн нууц мэдээллийг аливаа халдлагад өртөх, хулгайд алдагдах, гэмтэх, буруугаар ашиглах, нууцыг задруулах, хувилах, хуурамчаар үйлдэх, хувийн хэрэгцээнд эсвэл хууль бус болон нууцлаг зүйлд, ялангуяа интернет, интранет болон нийтийн сүлжээнд ашиглах явдлаас сэргийлэх үүрэгтэй.

Үүнд, техник, менежментийн мэдээлэл, үйлчлүүлэгч, боломжит үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэгчийн файлууд, програм хангамж, нууц үг, баримт бичиг болон зураг төсөл, аргачлалууд болон нөгү-хау, үйлдвэрлэлийн нууц, техникийн тохиргоо, оюуны болон үйлдвэрлэлийн өмч, таамаглалууд, гэрээ хэлэлцээр, өөрийн өртөг, танилцуулгад ороогүй борлуулалтын үнэ, стратегийн болон худалдааны төлөвлөгөө, судалгааны болон хөгжүүлэлтийн материал, шинэ

санаачилгатай холбоотой мэдээлэл, санхүүгийн болон компанийн мэдээлэл, мэргэжилтнүүд, шинжээчдийн нэр, холбогдох хаягийн мэдээллийг хамгаалах явдал багтана.

5.1.4 Хувийн мэдээллийг хамгаалах

Орано хувь хүний мэдээллийн нууцыг хамгаалахад анхаарч, Мэдээлэл хамгаалах ерөнхий журмын (GDPR) заалтуудыг дагаж мөрдөх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

5.2 ӨРСӨЛДӨӨН

Орано групп болон ажиллагсад нь Группийн үйл ажиллагааны хүрээнд, ялангуяа Групп өөрөө оролцох боломжтой аливаа арилжааны гэрээ, хэлэлцээний чөлөөт өрсөлдөөнд шууд болон шууд бусаар саад тотгор учруулахаас татгалзана. Тэд мөн аливаа хууль бус яриа хэлэлцээнд оролцох, Групп давуу тал, давуу эрх эдлэх боломжтой нөхцөл байдлыг хэтрүүлэн ашиглах, түүнчлэн өрсөлдөгчидтэйгээ шударга бусаар харилцах ёсгүй.

Орано групп болон ажиллагсад нь Франц Улс, Европын болон Олон Улсын өрсөлдөөний тухай хууль тогтоомж, мөн Групп нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж буй бүх орнуудын хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Гуравдагч тал, ялангуяа Группийн өрсөлдөгчдөд хамаарах аливаа мэдээллийг холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд олж авах, ашиглах ёстой.

5.3 ЭКСПОРТЫН ХЯНАЛТ

Цөмийн үйл ажиллагааны хувьд тус Групп нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ болон технологийг зөвхөн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх тухай хүчин төгөлдөр Олон Улсын гэрээний заалтуудыг дагаж мөрддөг, ОУАЭА-ын баталгаатай, экспортын хяналттай орнуудад болон тэдгээр оронд үйл ажиллагаа явуулдаг компаниудад нийлүүлдэг. Групп эдгээрээс өөр, аливаа нөхцлөөр ажиллахгүй.

Групп үйл ажиллагаа явуулдаг улс орнуудынхаа экспортын талаарх үндэсний хэмжээнд тавигддаг шаардлагыг хангахын зэрэгцээ ялангуяа хос зориулалттай зүйлсийн тухай болон олон улсын хориг, цээртэй холбоотой хууль тогтоомж болон дүрэм, журмыг баримтлан ажилладаг.

5.4 СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Ажилтан бүр үнэнч шударга байх ёстой бөгөөд Хавсралт дахь “Авилгын эсрэг дүрэм”-ийн заалтын дагуу аливаа ашиг сонирхлын зөрчлийг дээд шатны албан тушаалтандаа нэн даруй бичгээр мэдэгдэж, нэг хувийг Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан хэлтэст хүргүүлнэ. Энэ нь ажиллагсад өөрийн ажил үүргээ гүйцэтгэх явцдаа тэдний өөрсдийн эсвэл хамаатан садангийн хувийн ашиг сонирхол Орано группийн ашиг сонирхолтой зөрчилдөх аливаа тохиолдолд хамаарна.

Ажиллагсад нь өөрсдийгээ санаатайгаар ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөл байдалд оруулахгүй байхад анхаарч, ашиг сонирхлын зөрчил үүсгэх асуудлаар аливаа дүгнэлт, уулзалт эсвэл шийдвэр гаргах ажиллагаанд оролцохгүй.

5.5 ХЭЭЛ ХАХУУЛ, ЗҮЙ БУСААР НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ ОРОЛДЛОГО, БЭЛЭГ СЭЛТ БА АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ

Группийн ажиллагсад төрийн албаныхан, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчид, түншүүдтэйгээ харилцахдаа шударга байдлыг удирдлага болгоно. Орано групп нь дэлхийн хаана ажиллаж байхаас үл хамааран олон нийтийн эсвэл хувийн, идэвхтэй

эсвэл идэвхгүй хээл хахуулийн аливаа хэлбэрийг хориглодог. Зүй бусаар нөлөө үзүүлэх аливаа оролдлогыг мөн хориглодог.

Хавсралт дахь “Авилгын эсрэг дүрэм” нь Орано группийн удирдлагаас тус Группийг хээл хахууль болон зүй бусаар нөлөө үзүүлэх оролдлогоос урьдчилан сэргийлж, илрүүлэх тодорхой бөгөөд эргэлзээгүй байр суурьтай болохыг илэрхийлж байгаа юм. Дүрэмд үүнтэй холбогдуулан хориглох үйлдлүүдийг тайлбарлаж, Авилгын эсрэг дүрмийг зөрчсөн аливаа үйлдэл болон үүссэн нөхцөл байдлын талаарх мэдээллийг ажиллагсдаас цуглуулах зорилготой шүгэл үлээх дотоод системийн тухай нарийвчилсан мэдээллийг тусгасан.

5.6 ДОТООД МЭДЭЭЛЛИЙГ УРВУУЛАН АШИГЛАХ

Компанийн удирдлага болон нийт ажиллагсдад мэргэжлийн нууцлалыг хадгалах тухай сануулж, мөн тэд хамаатан садантайгаа ажилд хамааралтай сэдвээр ярилцахдаа хянуур болгоомжтой байх үүрэгтэй болохыг нь сануулна. Үүнийг зөрчсөнөөс дотоод мэдээллийг урвуулан ашиглах нөхцөл байдал үүсэх аливаа тохиолдлын тухай ажиллагсдад анхааруулах бөгөөд тэд дотоод мэдээллийг ашиглахдаа Группийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бодлогыг чанд сахих ёстой.

Хуулийн дагуу, компанийн удирдлага нь Группээс арилжааны зориулалтаар гүйлгээнд гаргасан үнэт цаас, ялангуяа Орано группийн хувьцаа мөн Орано групп гүйлгээнд гаргасан өрийн хэрэгсэл, эсвэл хөрөнгийн бирж дээр бүртгэгдсэн эсвэл бүртгэгдээгүй охин компаниудын хувьцааг шууд болон шууд бусаар эзэмших эсвэл худалдах тохиолдолд зөвхөн Группийн дотоод мэдээллийг хамгаалах тухай бодлого, журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэ тухайгаа компанийн хяналт хариуцсан алба, хэлтэст нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

5.7 ЁС ЗҮЙН СЭРЭМЖЛҮҮЛЭГ БОЛОН ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ТЭРГҮҮН ЗЭРГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг зөрчих, илэрхий алдаа гаргах эсвэл энэхүү Ёс зүйн дүрэм эсвэл хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх талаарх бодлогыг зөрчсөн асуудал илрэх тохиолдолд нэн даруй сэрэмжлүүлэн мэдэгдэх нь ажилтан нэг бүрийн зайлшгүй хийх алхам, мөн үүрэг нь юм. Энэ төрлийн мэдээллийг дотооддоо дамжуулахад удирдлагын зүгээс ямар нэгэн саад тотгор учруулахгүй бөгөөд мөн удирдах албан тушаалтанд нэн даруй сэрэмжлүүлэн мэдэгдэхэд хэн, ямар албан тушаалтай байх нь үл хамаарна.

Ёс зүйн шинжтэй аливаа тодруулга эсвэл санаа зовоосон асуудал гарвал уг ажилтан энэ асуудалд хариулт өгч чадах Орано группийн ажилтантай ярилцах хэрэгтэй. Түүнчлэн, уг ажилтан өөрийнхөө шууд болон шууд бус удирдлага, менежментэйгээ уг асуудлаар ярилцах, эсвэл Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан ажилтан, нэгж, хэлтэст, эсвэл Группийн Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан захиралтай холбогдох боломжтой бөгөөд эдгээр хүмүүсээс ёс зүйн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөгөө авч болох ба тэдэнтэй холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг Группийн www.orano.group веб хуудас болон Интранетээс авч болно. Франц Улсын хуулийн дагуу, Орано групп шүгэл үлээгчдийн нууцыг хадгалж, халдашгүй байдлыг нь бүрэн хамгаалах баталгаа гаргана.

Орано группийн Ёс зүйн дүрэм эсвэл түүнийг дагаж мөрдөх бодлого, журамтай илт харшилсан даалгавар хүлээн авсан бол тэрхүү даалгаврыг биелүүлэхгүй байх нь ажилтан бүрийн үүрэг байна. Тэрбээр, уг асуудлыг Группийн удирдлагад нэн даруй мэдэгдэж, баримтыг зохих ёсоор тэмдэглүүлэх бөгөөд уг баримт нотлогдвол энэ асуудлаар санаа зовох ёсгүй.



orano

5.8 ХАРИУЦЛАГА ТООЦОХ

Группийн Ёс зүйн дүрэм эсвэл хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах бодлого болон дотоод журмыг зөрчсөн этгээдэд сахилгын шийтгэл оногдуулах (гаргасан зөрчлөөс хамааран компанийн дотоод журмын дагуу анхааруулах, зүй бус үйлдэлд хариуцлага тооцож ажлаас халах хүртэл арга хэмжээ авна) эсвэл шүүхээс хуулийн хариуцлага тооцох хүртэл арга хэмжээ авна. Сахилгын шийтгэл ноогдуулахдаа Группийн үйл ажиллагаа явуулж байгаа тухайн улс оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх ёстой.

6. ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

Орано группийн Ёс зүйн дүрмийг биелүүлэх нь бид бүгдийн үүрэг юм. Менежерүүд үлгэр жишээч ёс зүйтэй байх шаардлагатай бөгөөд §5.7-д заасан ёс зүйн сэрэмжлүүлгийн системийг ашиглан ёс зүйн болон түүнийг дагаж мөрдөхтэй холбоотой багийнхаа ажилтнуудын асуултанд хариулт өгөх, эсвэл тэднийг Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан нэгж, хэлтэс, ажилтантай холбох үүрэгтэй.

Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан ажилтан, нэгж, хэлтэс нь хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах талаарх Группийн бодлого болон тодорхой салбарын хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангахтай холбоотой бодлого журмыг таниулан түгээхэд нь салбаруудын удирдлагад дэмжлэг үзүүлэн ажиллана. Үүнд: авилга, зүй бусаар нөлөө үзүүлэхийг оролдох явдлаас урьдчилан сэргийлэх, өрсөлдөөний тухай хууль тогтоомж болон дүрэм, журмууд, хос зориулалттай зүйлсийн экспортын тухай дүрэм, журмууд, эдийн засаг, худалдааны хориг, цээрийн тухай г.м.

Орано групп нь Ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгах аар аудит хийж болох бөгөөд түүнийгээ Орано группийн Мэдээллийн технологийн дүрмийн дагуу явуулна.



orano

7. ОРАНО ГРУППИЙН ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ХАВСРАЛТ

АВИЛГЫН ЭСРЭГ ДҮРЭМ

Өмнөтгөл

Авилга, зүй бусаар нөлөө үзүүлэх оролдлогоос урьдчилан сэргийлэх нь Орано группийн нийт ажиллагсадын хувьд онцгой ач холбогдолтой асуудал юм. Учир нь бидний Ёс зүйн дүрэм болон энэхүү Авилгын эсрэг дүрэм нь шударга байдал, үлгэр жишээч байх бидний үнэт зүйлс болон ил тод байдлын талаар бариталдаг зарчимтай зөрчилддөг аливаа ажиллагааг үндсээр нь устгахын төлөө хамтдаа ажиллах зорилгоор дэлхийн өнцөг булан бүрт ажиллаж байгаа Группийн ажиллагсдад төдийгүй үйлдвэрлэл, худалдааны түншүүдэд маань зориулагдсан.

Энэхүү дүрэм нь ажиллагсдад эрсдэлтэй байж болзошгүй нөхцлүүдийг танихад нь туслах, мөн асуудлыг тухайн нөхцөлд тохируулан шийдэхэд ашиглаж болох үндсэн нөхцөлөөр ханган туслалцаа үзүүлэх зорилготой юм. Дэлгэрэнгүй журмыг Интранетээс үзэж болох бөгөөд шаардлагатай тохиолдолд, манай Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан нэгж, хэлтэс, ажилтнууд тодруулга өгч, туслалцаа үзүүлэх боломжтой.

1. ҮНДСЭН ЗАРЧИМ

Группийн ажиллагсад, удирдах албан тушаалтан болон Группийн бусад төлөөлөгчдийн зүгээс төрийн байгууллагууд, үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчидтэйгээ тогтоосон болон цаашид тогтоох ажил хэргийн харилцаандаа шударга байх зарчмыг удирдлага болгоно.

Орано групп төрийн болон хувийн хэвшлийнхэнд авилга өгөх эсвэл тэднээс идэвхтэй, идэвхгүй бүх хэлбэрээр авилга авахыг хориглодог бөгөөд авилга авсан, өгсөн үйлдэл эсвэл зүй бусаар нөлөөлөх оролдлого хийсэн нь нотлогдсон тохиолдолд өршөөхгүй байх зарчмыг баримталдаг.

Орано групп нь Франц Улсын болон олон улсын эсвэл гадаадын төр, засгийн газрын байгууллагууд, эсвэл тэдний ажилтнуудад зүй бусаар нөлөөлөх (шан харамж амлан өөртөө ашигтай үйлдэл хийлгүүлэх, шийдвэр гаргуулах) оролдлого хийхийг хориглодог.

Эцэст нь, Орано групп ашиг сонирхлын зөрчлийг зохих ёсоор шийдвэрлэдэг бөгөөд ашиг сонирхлын зөрчил нь Ёс зүйн дүрмийг зөрчих ёсгүй гэж үздэг.

2. ДҮРЭМ, ЖУРАМ

2.1. ХОРИГЛОХ ҮЙЛДЛҮҮД

Орано групп хууль бусаар гэрээ тендерт ялах, гэрээгээ хадгалж үлдэх эсвэл худалдааны давуу эрхтэй байх, тухайн эрхийг олж авах зорилгоор аливаа улс төрч, төрийн болон хувийн хэвшлийн ажилтанд тодорхой хэмжээнээс /хэрэв холбогдох хууль тогтоомжоор тодорхой хэмжээг зөвшөөрсөн бол/ давсан үнэтэй төлбөр эсвэл

үйлчилгээ, бэлэг сэлт эсвэл амралт, зугааг шууд эсвэл шууд бусаар өгөх, санал болгох, амлах эсвэл хэн нэгнээс шаардахыг хориглоно; эдгээр нь идэвхтэй авилгын гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцогдоно.

Түүнчлэн, Орано групп нь ямарч тохиолдолд өөрийн болон бусдын нэрийн өмнөөс, өөртөө болон бусдад аливаа этгээдийн бодит болон таамагласан нөлөөг буруугаар ашиглан аливаа төр, захиргааны байгууллагаас болон бусдаас давуу байдал, ажил олж авах, гэрээ байгуулах эсвэл тэдгээрээр эерэг шийдвэр гаргуулах зорилгоор өөрсдийгөө болон бусдыг шахалтад оруулах эсвэл амлалт, хандив, бэлэг сэлт, шан харамжийг шууд болон шууд бусаар өгөхийг хориглоно; Франц Улсын хуулийн дагуу, зүй бусаар нөлөөлөх оролдлого нь гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцож, тухайн тохиолдолд хуулийн хариуцлага хүлээлгэдэг.

Мөн, албан тушаалаа урвуулан ашиглаж, холбогдох журмыг зөрчиж гэрээ байгуулах, ажил олгох, эсвэл аливаа эерэг шийдвэр гаргуулахаар ажил, албан аливаа зүйлийг санал болгох, амлах, хандив өргөх, бэлэг сэлт эсвэл шан харамж өгөх, авах эсвэл өгөхийг шаардахыг Орано группын ажиллагсад болон түншүүдэд хатуу хориглоно; эдгээрийг идэвхгүй авилгын гэмт хэргийн шинжтэй үйлдэлд тооцож, хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

Ажиллагсад агшин төдийд ч гуравдагч этгээдэд өртэй мэт сэтгэгдэлтэй үлдэх, эсвэл аливаа үл ойлгогдох нөхцөл, түүнтэй төстэй аливаа эргэлзээтэй, ойлгомжгүй байдалд өөрсдийгөө оруулахаас зайлсхийх ёстой.

Группийн бодлогод авилга болон зүй бусаар нөлөөлөх оролдлогоос урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг нарийвчлан тусгаж, хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээрийг бүгд дагаж мөрдөх ёстой.

2.2. БЭЛЭГ СЭЛТ, УРИЛГА БОЛОН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Орано групп нь бага үнэтэй гарын бэлгийг цөөн тохиолдолд өгөх эсвэл авах нь бизнесийн сайн харилцааг хөгжүүлэхэд зарим талаар тусалдагийг хүлээн зөвшөөрдөг.

Тийм ч учраас, төрийн болон хувийн салбарт ажиллагсад нь холбогдох хууль, журмыг хатуу сахин мөрдөж, ил тод байдлаар, ажил хэргийн хүрээнд бөгөөдхоёрдогч санаагүй, тодорхой шалтгаантай бэлэг сэлт эсвэл урилгыг өгч эсвэл хүлээн авч болно. Харин тэдгээр зүйлс нь шийдвэр гаргахад хэзээ ч нөлөөлөх ёсгүй бөгөөд мөн бэлэг өгсөн этгээд болон ашиг хүртэгч талуудад шийдвэр гаргахад нөлөө үзүүлж буй мэт сэтгэгдэл төрүүлэх ёсгүй. Бэлэг сэлт болон урилгыг холбогдох байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгаж, баримтжуулах шаардлагатай.

Ажиллагсад энэхүү асуудлаар ухаалаг шийдвэр гаргаж, хариуцлагаа ухамсарласан байх шаардлагатай. Хэрэв эргэлзэж байвал бэлэг эсвэл урилгыг хүлээн авахаас татгалзах эсвэл өөрийн менежер болон Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан нэгж, хэлтсээс урьдчилан зөвшөөрөл авах ёстой.

Зарим онцгой тохиолдолд, ажилтан нь ажиллаж буй орныхоо зан заншлыг хүндэтгэж эсвэл ёслол, хүндэтгэлийн зарчмын дагуу үнэ цэнэтэй (бага хэмжээний үнэлгээнээс давсан) бэлэг сэлт, урилга хүлээн авах эсвэл өгөх шаардлага гарвал өөрийн удирдлагад энэ тухай мэдэгдэж, шаардлагатай бол бичгээр урьдчилан зөвшөөрөл авна.

Ялангуяа, бэлэн мөнгөөр төлбөр хийх, хувийн үйлчилгээ үзүүлэх, зээл, урилга болон тохиромжгүй бэлэг сэлтийг эсвэл бизнесийн харилцаанд тохиромжгүй газар тэдгээрийг өгөхийг хориглодог.

Группийн дотоод бизнес нэгжүүд болон салбар компаниудын хооронд бэлэг сэлт солилцох, зардлын тооцоог компани дотроо зохицуулалт хийхийг хориглоно.

Цөөн тохиолдолд үйлчлүүлэгчдэд зориулан зохиох арга хэмжээ нь хууль ёсны, арилжааны зорилготой байх ёстой бөгөөд тэдгээрт зориулсан бүх зохицуулалтын талаар холбогдох шатны зөвшөөрлийг урьдчилан авсан байна.

Энэ тохиолдолд би яах ёстой вэ...?

- *Нэгэн ханган нийлүүлэгч намайг одоо зарлагдаад байгаа тендерийн үйл явцад “зөв шийдвэр гаргана” хэмээн найдаж нэр хүндтэй тусгай арга хэмжээнд урьсан.*
 - Арилжааны шийдвэрт нөлөө үзүүлэхүйц эсвэл нөлөөлсөн гэж харагдах аливаа бэлэг эсвэл урилгаас эелдэгээр татгалзах ёстой бөгөөд та энэ тухайгаа холбогдох удирдлага болон Дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан ажилтанд мэдэгдэх ёстой.
- *Манай багийн нэг борлуулагч удахгүй зарлагдах тендерийн талаар мэдээлэл олж авах зорилгоор нэгэн үйлчлүүлэгчийн ажилтныг гэр бүлийн хүнтэй нь оройн хоолонд урих санал оруулсан.*
 - Та тэр борлуулагчид энэ төрлийн үйлдэл нь Группийн бодлоготой нийцэхгүй гэдгийг тайлбарлаж, түүнийг сургалтад хамруулна уу. Менежерүүд болон компанийн удирдлага Ёс зүйн дүрэм, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах тухай Группийн бодлогын талаар багийн гишүүддээ тогтмол сануулж байх шаардлагатай.

2.3. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

Нийт ажиллагсад үнэнч шударга байх ёстой бөгөөд аливаа ашиг сонирхлын зөрчлийн тохиолдлын талаар удирдах албан тушаалтандаа нэн даруй бичгээр мэдэгдэж, нэг хувийг Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан хэлтэст хүргүүлнэ. Энэ нь ажиллагсад ажил үүргээ гүйцэтгэх явцад өөрсдийнх нь эсвэл тэдний хамаатан садангийн хувийн ашиг сонирхол Орано группийн ашиг сонирхолтой зөрчилдөх аливаа тохиолдолд хамаарна. Үүнд, Орано групптэй хамтран ажилладаг эсвэл ажиллахаар зэхэж буй аливаа ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч, мэдэгдэж буй өрсөлдөгчид болон аливаа байгууллага, хувь хүмүүс багтана.

Ажиллагсад нь өөрсдийгөө ашиг сонирхлын зөрчил үүсгэх нөхцөл байдалд санаатайгаар оруулахгүй байхад анхаарч, ашиг сонирхлын зөрчил үүсгэх асуудлаар аливаа дүгнэлт, уулзалт эсвэл шийдвэр гаргах ажиллагаанд оролцох ёсгүй. Ялангуяа, Группийн ажилтны эхнэр, нөхөр, хүүхэд эсвэл хамаатан садангийн хүмүүсийг зөвхөн ажилтны удирдах албан тушаалтан зөвшөөрсний үндсэн дээр ажилд авч эсвэл гэрээгээр ажиллуулж болох бөгөөд ойлгомжгүй, сэжигтэй эсвэл танил талаа ашигласан байдал гаргахаас урьдчилан сэргийлэхийн тулд тухайн хүнийг ажилд шалгаруулахдаа бодит шалгуур дээр үндэслэнэ. Группийн холбогдох ажилтан өөрийнх нь хамаатан садангийн хүмүүсийг сонгон шалгаруулахад оролцохгүй. Түүнчлэн, Группийн ажилтны эхнэр, нөхөр, хүүхэд эсвэл хамаатан садангийн хүмүүс уг ажилтны шууд эсвэл шууд бус удирдлага дор ажиллаж болохгүй.

Удирдлагад мэдэгдсэн ашиг сонирхлын зөрчлийг удирдлагын нэг, хоёр дахь шатны түвшинд асуудал тус бүрт дүн шинжилгээ хийж, уг зөрчлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох дараах нөхцлүүдийг (жагсаалт дараахаар хязгаарлагдахгүй) заавал мэдэгдэх ёстой. Үүнд:

- компанийн удирдах албан тушаалтан эсвэл түүний хамаатан садангийн хэн нэг нь зөвлөх, санхүүгийн түнш эсвэл бусад үйлчлүүлэгч болон ханган нийлүүлэх компанид эсвэл Группийн өрсөлдөгч компанид хувийн сонирхолтой байх;
- компанийн ажилтан эсвэл түүний хамаатан садангийн хэн нэг нь Групптэй холбоотой ажилладаг өөр компанийн удирдах зөвлөлийн гишүүн захирал эсвэл удирдах албан тушаалтан байх;
- компанийн ажилтан эсвэл түүний хамаатан садангийн хэн нэг нь зөвлөх эсвэл Групптэй холбоотой ажилладаг эсвэл ажиллахаар зэхэж буй өөр компанийн менежментийн багт ажилладаг эсвэл борлуулалт, хангамж, худалдан авалтын хэлтэст алба хашдаг байх;
- компанийн ажилтан эсвэл түүний хамаатан садангийн хэн нэг нь байр, тоног төхөөрөмж эсвэл хувийн өмч хөрөнгөө Группт төлбөртэй ашиглуулах.

Энэ тохиолдолд би яах ёстой вэ...?

- *Миний бие сонгон шалгаруулах үйл явцад нь оролцож байгаа тендерт/ дуудлага худалдаанд манай гэр бүлийн нэг гишүүн ханган нийлүүлэгчийг төлөөлөн оролцоно гэдгийг би олж мэдсэн.*
 - Та өөрийн шууд удирдлага болон түүний шууд удирдлагад энэхүү ашиг сонирхлын зөрчлийн тухай мэдэгдэж, төслөөс нэрээ татаж авах ёстой.

2.4. ГУРАВДАГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ, ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ

Группын бүх нэгж болон менежерүүд аливаа мөнгөн дүнгийн бодит эх сурвалж болон хэрэглээг ямарч тохиолдолд хангалттай баталгаажуулж чаддаг байх ёстой.

Холбогдох гэрээний баримт бичиг болон санхүүгийн тайлан тооцоонд утгыг нь бүрэн гүйцэд, нарийвчлан тайлбарлаагүй бол ямарч төлбөрийг хийх буюу хүлээн авах ёсгүй.

Төлбөр төлөгч эсвэл төлбөр хүлээн авагчийн хэн болохыг нуун дарагдуулсан эсвэл нуун дарагдуулахыг оролдсон төлбөрийн арга хэрэгслийг хүлээн зөвшөөрөхгүй.

Давуу байдал олгох аливаа төлбөр хийхийг хориглоно.

Шударга байдлыг хангах үүднээс эрсдлийн тогтоогдсон түвшнээс шалтгаалан Orano-тай хамтран ажилладаг гуравдагч талуудыг тусгайлан шалгаж баталгаажуулна.

Энэ тохиолдолд би яах ёстой вэ...?

- *Ханган нийлүүлэгч өөр улс дахь банкны дансандаа төлбөрөө шилжүүлүүлэхийг хүсэх.*
 - Зарчмын хувьд, ханган нийлүүлэгчийн банкны данс нь бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа газартай холбогдолтойгоор оршин суугаа улс оронд нь байдаг. Хэрэв тийм биш байвал, уг хүсэлтийг хүлээн авах боломжтой эсэхийг тодорхойлохын тулд та шалтгааныг нь тодруулахаар хүсэлт гаргах хэрэгтэй.
- *Төрийн албан хаагч намайг нэмэлт төлбөр шууд төлвөл холбогдох бичиг цаасны асуудлыг илүү хурдан шийдэх боломжтой гэсэн.*

Энэ бол давуу байдал олгох төлбөр. Манай Групп давуу байдал олгох аливаа төлбөрийг хийхээс татгалзах бодлого барьдаг бөгөөд ийм

төрлийн үйл ажиллагааг хуулиар зөвшөөрсөн улс оронд ч зөвшөөрдөггүй.

2.5. БОРЛУУЛАЛТЫН ЗУУЧЛАГЧИД

Групп нь арилжааны гэрээ олж авах, тэдгээр гэрээний гүйцэтгэлийг хянах эсвэл Группийн үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор судалгаа хийх эсвэл аливаа бусад арга хэмжээг авах, зохион байгуулахаар борлуулалтын зуучлагчид болон агентуудыг ажиллуулж болно. Хамтран ажилладаг зуучлагчид нь үйл ажиллагаагаа явуулахдаа бидний үнэт зүйлс болон үйл ажиллагаа явуулж буй улс, орны хууль тогтоомжид нийцүүлэн, шударга байдлын хувьд бидэнтэй ижил зарчмуудыг баримталж буй эсэхийг баталгаажуулна. Борлуулалтын зуучлагчдыг сонгон шалгаруулахад нэн ялангуяа магадлан шинжилгээ, гэрээтэй холбоотой төлбөр тооцооны асуудалд онцгойлон анхаарал хандуулах ёстой.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм, журмын дагуу, борлуулалтын зуучлагчидтай хамтран ажиллахын тулд урьдчилан шалгаж, баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд гэрээ байгуулахдаа авилгын эсрэг болон гэрээний хэрэгжилтийг хангахтай холбоотой заалтууд уг гэрээнд тусгагдсан эсэхийг тусгайлан нягтлах шаардлагатай..

Энэ тохиолдолд би яах ёстой вэ...?

- *Манай агент өртөг, зардлаа улам нэмсэн байдлаар давтан нэхэмжлэл ирүүлж байгааг би ажигласан.*
 - Өртөг, зардлын тооцоог нөхөн төлөх нөхцөл нь зарчмын хувьд гэрээнд тусгагдсан байдаг. Тэдгээр нь аливаа бусад үйлчилгээний адил үндэслэлтэй байх ёстой. Төлбөрийн баримтыг шаардаж, агентаас тайлбар өгөхийг хүсэх ёстой.
- *Манай үйл ажиллагааг саадгүй явуулах үүднээс төр, захиргааны холбоотой асуудлыг зохицуулна гэж хэлсэн зуучлагчтай хамтран ажиллаж байгаа.*
 - Энэхүү зуучлагчаас гуравдагч талд хээл хахуул төлвөл Группыг шууд бус авилга өгсөн хэрэгт холбогдуулж болох тул үүнээс зайлсхийхийн тулд зуучлагчийн үйлчилгээний хүрээг сайтар тодорхойлж, баримтжуулан, мөн зуучлагчийн үнэлгээний нэхэмжлэл нь зах зээлийн шударга үнэлгээтэй нийлж байгаа эсэхийг нягтлах шаардлагатай. Түүнчлэн, аудит хийх нөхцөлийг гэрээнд тусгах боломжтой.

2.6. СОНИРХЛЫН ТӨЛӨӨЛӨЛ БА УЛС ТӨРИЙН НАМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Ерөнхийд нь лоббидох гэж нэрлэдэг, төрийн байгууллагуудад үзүүлэх сонирхлын төлөөллийн асуудлыг Улс орон, Олон Улсын байгууллага тус бүрийн дагаж мөрддөг хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохицуулна. Франц Улсад, аливаа ажилтан болон байгууллагын албан хаагч нь эрх бүхий аливаа этгээдтэй аливаа шийдвэрийг өөрчлүүлэхээр холбогдохдоо сонирхлын төлөөлөлтэй холбоотой хууль тогтоомж болон хүчин төгөлдөр дүрэм, журмыг дагаж мөрдөх ёстой байдаг.

Улс төрийн намуудыг санхүүжүүлэх тухайд, Группын нэг ч салбар, компани аливаа улс төрийн нам, төрийн албан хаагч эсвэл ийм албан тушаалд нэр дэвшигчид санхүүжилт өгдөггүй, аливаа үйлчилгээ үзүүлэхгүй.

Гэхдээ, байгууллага ийм төрлийн хандив өргөх явдлыг хууль ёсоор хүлээн зөвшөөрдөг ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувьд, тухайн улс орны хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд сонгуулийн кампанит ажилд зориулан

хандив өргөж болно. Тэрхүү хандивыг өргөхийн тулд тухайн салбар компанийн эрх бүхий удирдах албан тушаалтнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах ёстой бөгөөд тэрбээр ийм төрлийн зөвшөөрлийг цөөн тоогоор хязгаартай олгох үүрэгтэй.

Ийнхүү олгох мөнгөн дүн, түүнийг хүлээн авагч талуудын нэрийг тухайн салбар компанийн эрх бүхий удирдах албан тушаалтны бэлтгэх жил тутмын ёс зүйн тайлангийн хавсралт хураангуйд мэдээлнэ.

Энэ тохиолдолд би яах ёстой вэ...?

- *Миний бие парламентын төлөөлөгчид цөмийн энергийн ач холбогдлын талаар тайлбарласны дараа, ярилцлага дөнгөж дуусмагц тэрбээр сонгуулийн тойрогтоо барих спортын төвийг санхүүжүүлэх боломжтой юу гэж асуусан.*
 - Ивээн тэтгэх асуудлыг Групп бодлогоор зохицуулдаг бөгөөд тодорхой процессын дагуу батлуулах шаардлагатай байдаг гэдгийг та эелдэгээр тайлбарлаад татгалзах ёстой. Ийм хүсэлт нь зүй бусаар нөлөөлөх оролдлого хийх тохиолдолд багтана.

2.7. БАЙГУУЛЛАГЫГ ИВЭЭН ТЭТГЭХ, ХАНДИВ ӨРГӨХ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ

Группийн ивээн тэтгэх бодлого болон үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөг Группийн түвшинд тодорхойлсон бөгөөд тэдгээр хөтөлбөрүүдэд ажиллагсдыг татан оролцуулах талаар тусгасан.

Үзэл санаа: Orano-н оролцоо нь Группийн үнэт зүйлсийн тусгал байдаг. Тэдгээр нь захиргааны болон арилжааны ямарч хэлбэртэй байсан тусыг тусаар гэдэг зарчмаар явагддаггүйгээрээ онцлогтой.

Зохицуулалт: Манай Групп зөвхөн түншийн үүрэгтэй оролцдог ба гол гэрээлэгч эсвэл гүйцэтгэгчийн үүрэг хариуцлага хүлээлгүй, шаардлагатай бүх хууль зүйн болон захиргааны албажуулалтыг хийж, шаардагдах зөвшөөрөл болон баталгааг авсны дараа санаачлагчдын удирдан хэрэгжүүлж байгаа төсөл болон хөтөлбөрүүдийг зөвхөн дэмждэг.

Orano группийн ивээн тэтгэх үйл ажиллагаанд Төрийн эсвэл бүс нутгийн захиргааны байгууллагад эсвэл аливаа хувь хүнд ямар нэгэн бэлэг эсвэл бэлэн мөнгө төлөх явдал багтахгүй.

Энэ тохиолдолд би яах ёстой вэ...?

- *Улс төрч надаас охидын боловсролын чиглэлээр ажилладаг буяны байгууллагыг ивээн тэтгэхийг хүссэн. Уг холбоог түүний эхнэр удирддаг.*
 - Ямар нэгэн холбоог дэмжих болвол урьдчилан батлуулах шаардлагатай. Ийм төрлийн санхүүжилт нь авилгын нэг хэлбэрт тооцогдоно.

3. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

Энэхүү дүрмийг манай Группийн бүх ажиллагсад мөн гадны болон түр гэрээлэгчид мөрдөж ажиллана.

Энэхүү дүрэм нь Orano Групп үйл ажиллагаагаа явуулж байгаа дэлхийн аль ч улс оронд үйлчлэх ба хүчин төгөлдөр бөгөөд, авилгын эсрэг илүү өндөр шаардлагуудыг тусгасан дүрэм, журмуудыг орлохгүй.



orano

4. СУРГАЛТ

Орано групп ажиллагсад болон удирдах албан тушаалтнуудаа авилга, зүй бусаар нөлөөлөх оролдлого хийх эрсдлийг илрүүлэх сургалтанд заавал хамруулах ба Групп дэх тэдний үүрэг хариуцлага өөрчлөгдсөн тохиолдолд сургалтын агуулгыг тогтмол шинэчилж байдаг. Тэдгээр ажилтан, удирдах албан тушаалтнууд Группийн Хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хариуцсан нэгж, хэлтсээс нэмэлт мэдээлэл авах боломжтой.

5. ТАЙЛАГНАХ

Идэвхтэй болон идэвхгүй хэлбэрийн авилга, эсвэл зүй бусаар нөлөөлөх оролдлого, ийм төрлийн авилгыг дэмжсэн гуравдагч талын турхиралт зэрэг аливаа үйл ажиллагааг ажиглаж мэдсэн тохиолдолд шууд болон шууд бус удирдлага мөн/эсвэл Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан ажилтан, нэгж, хэлтэс эсвэл Группийн Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт хариуцсан Захиралд даруй мэдэгдэх шаардлагатай. Ёс зүйн асуудлыг Франц Улсын хуулийн дагуу хэрхэн шийдэх талаар эдгээр ажилтнуудтай зөвлөлдөх боломжтой бөгөөд тэдэнтэй холбогдох нарийн мэдээллийг Группийн веб хуудас болон Интранет дээрээс авах боломжтой. Тэд зохих арга хэмжээг цаг алдалгүй авч, тухайн тохиолдлын бодит байдлыг шаардлагатай бол аудит хийх зэргээр шалган тогтоож, хэрэв нотлогдвол ийм төрлийн зүй бус үйлдлийг нэн даруй зогсооно.

Өөрийн олж мэдсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл эсвэл буруутай үйлдлийг сайн санааны үүднээс илчилсэн, мэдээлэл өгсөн хүний нууцлалыг чанд хадгалах баталгааг хуулиар олгодог. Түүнчлэн, дээрх журмын дагуу баримттай мэдээлэл өгсөн хүний халдашгүй дархан эрхийг аливаа төрлийн хориг эсвэл ялгаварлан гадуурхах байдлаас хамгаалах баталгаа гаргана.

Мөн онц ноцтой, шууд аюул занал эсвэл нөхөж баршгүй хохирол учруулах эрсдлээс бусад төрлийн мэдэгдлийг гурван сар хүртэл хугацаанд олон нийтэд зарлахыг хуулиар хориглодог гэдгийг санах хэрэгтэй. Уг мэдээллийг зөвхөн хоригийн хугацаа дуусч, тухайн асуудал цаашид аливаа нөлөө бүхий үр дагавар учруулаагүй тохиолдолд олон нийтэд зарлаж болно.

6. ХОРИГЛОХ ЗҮЙЛС

Энэхүү Авилгын эсрэг дүрмээр хориглосон бүх үйлдэл, эсвэл тус дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн буруутай этгээдэд сахилгын шийтгэл оногдуулах (гаргасан зөрчлөөс хамааран компанийн дотоод журам, дүрмийн дагуу анхааруулах, зүй бус үйлдэл гаргасны төлөө ажлаас халах хүртэл арга хэмжээ авна) эсвэл шүүхийн шийдвэрээр хуулийн хариуцлага тооцох хүртэл арга хэмжээ авна. Сахилгын шийтгэлийг тухайн улс оронд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн хүрээнд ноогдуулна.

8. БАРИМТ БИЧГИЙН ОНЦЛОГ - ХЯНАН ЗАСВАРЛАСАН ШАЛТГААН

R0	<ul style="list-style-type: none"> • Энэхүү баримт бичгийг Orano-н форматад оруулсан бөгөөд CM ARV DIR CPL1 АРЕВА-гийн Шинэ Ёс зүйн дүрмийн оронд хэрэглэнэ. • Ёс зүйн дүрэм, Авилгын эсрэг дүрэм гэсэн 2 хэсгийг дахин томъёолж, нэмж өөрчилсөн бөгөөд бусад бүх хэсгийг хэвээр үлдээсэн. (өөрчлөлтийг доор дурдав) • Ёс зүйн дүрмийн хэсэгт: <ul style="list-style-type: none"> ○ Өмнөх үгт Ф. Варин, Ф. Knoш нарын тэргүүн өгүүллийг нэмсэн, ○ §2 Orano-н үнэт зүйлсийг нэмсэн ○ §5.1.1 чанарыг нэмсэн ○ §5.1.4 хувийн мэдээллийг хамгаалах тухай нэмсэн ○ §5.5 зүй бусаар нөлөөлөх оролдлогыг нэмсэн • Ил тод байдал, авилгатай тэмцэх болон эдийн засгийг шинэчлэхтэй холбоотой Франц Улсын 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 2016-1691 хуультай нийцүүлэх, мөн Авилгын эсрэг дүрмийг Ёс зүйн дүрмийн хавсралтаар оруулсан. <ul style="list-style-type: none"> ○ 2016 оны Ёс зүйн дүрмээс хээл хахуул: бэлэг сэлт, сонирхлын зөрчил, төлбөрүүд, борлуулалтын зуучлагчид, улс төрийн намын санхүүжилттэй холбоотой сэдвүүдийг дахин боловсруулсан. ○ §1 зүй бусаар нөлөөлөх оролдлогыг нэмсэн. ○ §2.1 хориглох зүйлсийг нэмсэн ○ §2 эрсдэлтэй байж болох нөхцлүүдийг жишээгээр харуулж, хэрхэн хандах тухай нэмсэн. ○ §2.4 гуравдагч талуудыг нягтлаж шалгах тухай нэмсэн. ○ §2.6 сонирхлын төлөөллийн тухай нэмсэн. ○ §4 авилгын эсрэг сургалтыг нэмсэн.
----	---

АГУУЛГА

1. ӨМНӨХ ҮГ	3
2. ҮНЭТ ЗҮЙЛС.....	3
3. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ӨМНӨ ОРАНО ГРУППИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ.....	4
3.1 Тус групп үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хувьд	4
3.2 Үйлчлүүлэгчдийн хувьд.....	4
3.3 Ажиллагсадын хувьд.....	4
3.4 Хувьцаа эзэмшигчдийн хувьд.....	4
3.5 Ханган нийлүүлэгчид ба гэрээлэгчдийн хувьд.....	4
3.6 Олон нийтийн хувьд	5
3.7 Хүний эрхийг хүндэтгэх болон бусад зорилтууд.....	5
4. ОРАНО ГРУППИЙН ХҮЛЭЭЛТ	5
4.1 Ажиллагсдын хувьд	5
4.2 Ханган нийлүүлэгчид ба гэрээлэгчдийн хувьд.....	5
5. ОРАНО ГРУППИЙН ХЭМЖЭЭНД ХҮЧИН ТӨГӨЛДӨРҮЙЛЧИЛДЭГ ДҮРЭМ, ЖУРМУУД	6
5.1 Хүний амь нас, өмч хөрөнгийг хамгаалах	6
5.2 Өрсөлдөөн	7
5.3 Экспортын хяналт	7
5.4 Сонирхлын зөрчил.....	7
5.5 Хээл хахуул, зүй бусаар нөлөө үзүүлэх оролдлого, бэлэг сэлт ба албан тушаалаа урвуулан ашиглах.....	7
5.6 Дотоод мэдээллийг урвуулан ашиглах.....	8
5.7 Ёс зүйн сэрэмжлүүлэг болон ёс зүйн дүрмийн тэргүүн зэргийн ач холбогдол.....	8
5.8 Хариуцлага тооцох.....	9
6. ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ.....	9
7. ОРАНО ГРУППИЙН ЁС ЗҮЙН ДҮРМИЙН ХАВСРАЛТ	10
АВИЛГЫН ЭСРЭГ ДҮРЭМ	10
1. Зарчмууд.....	10
2. Дүрэм, журам.....	10
2.1. Хориглох үйлдлүүд.....	10
2.2. Бэлэг сэлт, урилга ба арга хэмжээ зохион байгуулах.....	11
2.3. Ашиг сонирхлын зөрчил	12
2.4. Гуравдагч талуудтай харилцах, төлбөр тооцоо хийх.....	13
2.5. Борлуулалтын зуучлагчид	14



orano

2.6. Сонирхлын төлөөлөл ба улс төрийн намыг санхүүжүүлэх	14
2.7. Байгууллагыг ивээн тэтгэх, хандив өргөх, хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх.....	15
3. Хэрэгжүүлэлт	15
4. СУРГАЛТ.....	16
5. ТАЙЛАГНАХ.....	16
6. ХАРИУЦЛАГ ТООЦОХ	16
8. БАРИМТ БИЧГИЙН ОНЦЛОГ - ХЯНАН ЗАСВАРЛАСАН ШАЛТГААН.....	17

Florence Ascher
Хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт
Хариуцсан Захирал

Philippe Knoche
Ерөнхий захирал